



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/172

Арвайхээр сум

Газрын талбайн хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт нэр бүхий 6 иргэний эзэмшил газрын талбайн хэмжээг өөрчилсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхийн талбайн хэмжээ өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/170 дугаар захирамжийн хавсралтын Б.Лхагвасүрэнтэй холбогдох хэсэг, 03 дугаар сарын 24-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай” А/169 дүгээр захирамж, 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/236 дугаар захирамжийн Д.Даваадоржтой холбогдох хэсэг, 10 дугаар сарын 05-ны өдрийн “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” А/460 дугаар захирамжийн хавсралтын Т.Бат-Амгалан, Б.Наранцогттой холбогдох хэсэг, 2004 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” 107 дугаар захирамжийн хавсралтын Д.Оюунбилэгтэй холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0314

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 1172 дугаар захирамжийн хавсралт



ГАЗРЫН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨХ ИРГЭН

Д/д	Газар эзэмшигч иргэний овог, нэр	Регистрийн дугаар	Өмнөх газрын хэмжээ (м ²)	Нэмэлт, хасалт хийгдэх газрын хэмжээ (м ²)	Өөрчлөгдсөн газрын хэмжээ (м ²)	Газрын зориулалт	Газрын байршлын хаяг, нэр	Хугацаа (жил)
1	Б.Лхагвасүрэн	ЙВ90061803	312	37	349	Гэр, орон сууцны хашааны газар	13 дугаар баг, Өгөөмөр-7 гудамж, 704 тоот	19 жил
2	С.Түмэндэлгэр	ЙЭ54051904	300	-39	261	Гэр, орон сууцны хашааны газар	8 дугаар баг, Өндөр дэнж-2, 210 тоот	15 жил
3	Д.Даваадорж	ЙЙ74011516	515	172	687	Автомашин засвар, үйлчилгээний газар	5 дугаар баг, Ч.Эрдэнэ-Очир-2, 212 тоот	8 жил
4	Б.Наранцогт	ЙЖ89041911	263	32	295	Амины орон сууц	13 дугаар баг, Дөл-1 гудамж, 113 тоот	29 жил
5	Т.Бат-Амгалан	ЙЮ96122718	263	30	293	Амины орон сууц	13 дугаар баг, Дөл-1 гудамж, 111 тоот	29 жил
6	Д.Оюунбилэг	ЦГ72071403	400	164	564	Гэр, орон сууцны хашааны газар	5 дугаар баг, Од-1 гудамж, 103 тоот	10 жил